



ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН **2021**

АГУУЛГА

1.1 БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	3
1.3 ТЕХНИК ТЕХНОЛОГИ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, СҮЛЖЭЭНИЙ БАГТААМЖ.....	9
1.4 БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ.....	17
1.5 2021 ОНД ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТ БА ГҮЙЦЭТГЭЛ	22
1.6 ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	23


1.1 БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК нь Монгол улсын нутаг дэвсгэрийг хамарсан мэдээлэл, холбооны үндсэн сүлжээ болох улс, хот хооронд, орон нутгийн дамжуулах байгууламжийн нэгдсэн сүлжээг эзэмшин, тэдгээрийн байнгын тасралтгүй ажиллагааг хангаж ажилладаг.

Өнөөгийн байдлаар 21 аймаг 301 сум, суурин газрыг хамарсан 19'548.5км шилэн кабелийн сүлжээ, Улаанбаатар хот, хөдөө орон нутагт 13'101 холбооны худаг, 1'028'292 метр урт бүхий сувагчлал, Улаанбаатар хот, 21 аймаг 332 суурин газарт үйлчилгээний болон техникийн байр, холбооны цамхаг бүхий харилцаа холбооны дэд бүтэц дээрээ суурилсан үйлчилгээг аж ахуйн нэгжүүдэд ижил тэгш нөхцөлөөр үзүүлдэг.

Компани үндсэн болон гэрээт нийт 1'622 инженер, техникийн ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд мэдээлэл харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч, төрийн болон хувийн хэвшлийн давхардсан тоогоор 299 байгууллагатай хамтран ажиллаж байна.

Зураг 1. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн үндсэн сүлжээний зураг



1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ



СУВГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
IPLC, IEPL, MPLS, VPN, STM



**УЛС ХООРОНДЫН
СҮЛЖЭЭ**



**БАЙР, ТАЛБАЙ
ЦАМХАГИЙН ТҮРЭЭС**



**ТЕХНИК МЕНЕЖМЕНТИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ**



**ХУДАГ СУВАГЧЛАЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭ**



**ХЭРЭГЛЭГЧИЙН
ШУГАМЫН ҮЙЛЧИЛГЭЭ**

Манай компани тайлант хугацаанд давхардсан тоогоор 299 байгууллагатай 6 төрлийн үйлчилгээгээр гэрээний хүрээнд хамтран ажилладаг.

Тоон суваг түрээс

Тоон суваг түрээслүүлэх гэрээгээр 25 байгууллагад 81.4 Гбит/сек урсгал борлуулдаг.

Интернэтийн бөөний үйлчилгээ

Нийт 16 гэрээт байгууллагатай хамтран ажиллаж 12.5 Гбит/сек урсгалын гэрээ байгуулан ажилласан.

Шөрмөс түрээс

Хот хоорондын шөрмөс түрээслүүлэх гэрээний хувьд 26 чиглэлд 7,844 км, хот доторх шөрмөс түрээслүүлэх гэрээгээр 9 байгууллагад 51,6 км шөрмөсийн үйлчилгээг түрээслэн ажилладаг.

Тоног төхөөрөмжийн байр, цамхаг түрээс

Гэрээний хүрээнд 99 байгууллагатай цамхаг, тоног төхөөрөмжийн байр талбай, цахилгаан тэжээлээр ханган хамтран ажилласан байна.

Худаг, сувагчлал түрээс

Улаанбаатар хотод 122 төрийн болон хувийн байгууллага аж ахуйн нэгжид 5.493 чиглэлд 5.432.5 км сувагчлал, давхардсан тоогоор 73.384 худагт техникийн нөхцөл гарган үйлчилгээ үзүүлж байна.

Техник менежмент

Энэ оны байдлаар үүрэн холбооны оператор компаниудын 1450 гаруй сайтын ашиглалт үйлчилгээ, 706 сайт, 3200 км гаруй шилэн кабелийн трасст урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээ, орон нутаг дахь бүх сайтын гэмтэл саатал засварлах ажлыг хийж гүйцэтгэлээ.

1.3 ТЕХНИК ТЕХНОЛОГИ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, СҮЛЖЭЭНИЙ БАГТААМЖ

Технологи ашиглалтын чиглэлээр:

Гаалийн Ерөнхий Газар болон Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн хооронд байгуулсан “Хилийн боомтууд дахь гаалийн байгууллагын зарим салбарыг шилэн кабелийн сүлжээнд холбох” гэрээний хүрээнд Бургастай, Эрэнцав, Арцсуурь, Ханги боомтуудад сүлжээнд холбох ажлуудыг хийсэн.

2021 онд Дорнод аймгийн Баянхошуу боомтыг шилэн кабельд холбох ажлын хүрээнд угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэсэн.

Архангай аймгийн Хашаат сум, Завхан аймгийн Арцсуурь, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорнод аймгийн Баянхошуу боомтууд, Булган аймгийн Хялганат, Хэнтий аймгийн Гурванбаян Хурх, ХэрлэнбаянУлаан, Дорнод аймгийн Ялалт багууд дундын 2 сайтын хамт шилэн кабелийн сүлжээнд холбогдож нийт 845Мбит/сек урсгалыг шинээр үүсгэн үүрэн операторууд болон төрийн байгууллагуудад үйлчилгээг үзүүлж эхлээд байна.

Хүснэгт 1. Шинээр шилэн кабельд холбосон сумдууд

№	Чиглэл	Нийт урсгалын багтаамж /Мбит/сек/	Мобиком	Юнител	УБЕГ	Гааль	ХХЕГ	МЦХ	БШУЯ
1	Завхан - Арцсуурь боомт	87	50	20		8	5	4	
2	Архангай - Хашаат сум	0							
3	Булган -Хялгант баг	60						50	10
4	Хэнтий - Гурванбаян Хурх баг	10							10
5	Хэнтий - Хэрлэнбаян -Улаан баг	10							10
6	Дорнод - Талбай 19	350		350					
7	Дорнод - Талбай 21	300		300					
8	Дорнод - Ялалт баг	0							
9	Дорнод - Баянхошуу боомт	16				8	8		
10	Сэлэнгэ -Алтанбулаг боомт	12			2		10		
	Нийт	845							

“Монгол Улсын аймаг орон нутгийг холбосон А зэрэглэлийн авто зам дагуу үүрэн холбооны тасалдалгүй сүлжээ байгуулах” төслийн хүрээнд аймаг орон нутгийн А зэрэглэлийн авто замд үүрэн холбооны сүлжээ тасалддаг цэгүүдэд үүрэн холбооны дахин дамжуулах сайт байгуулах судалгааг боловсруулсан.

Сүлжээний найдвартай ажиллагааг дээшлүүлэх ажлын хүрээнд Дорноговь, Завхан, Баянхонгор, Архангай, Ховд, Дорнод, Булган, Дундговь, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий аймгийн төвүүдэд ажиллаж байсан Cisco 3750 свичийн урсгалуудыг Cisco 3850 свич рүү шилжүүлэх ажлыг төлөвлөгөөт хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.

“Сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх ХУР систем” төслийн хэрэгжилтийн гүйцэтгэл байр 73.5 хувь, цамхаг 76.4 хувь, барилгын засварын ажил 91.3 хувь байна.
16 байрнаас 7 байранд тоног төхөөрөмжийн шилжүүлгийг бүрэн хийж ашиглаж байна.

Сүлжээний өргөтгөл, шинэчлэл, техник технологийн чиглэлээр


ОХУ-ын Транстелеком, БНХАУ-ын ЧайнаТелеком компаниудын хооронд транзит 200Гбит/сек урсгал дамжуулах техникийн бэлэн байдлыг хангаж, хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн картуудын угсралт суурилуулалт, хэмжилт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэн, урсгалыг ажиллагаанд бүрэн орууллаа.

ОХУ-ын Мегафон компанитай хилийн холболтыг шинээр хийж, Мегафон болон БНХАУ-ын ЧайнаЮником компаниудын хооронд транзит 100Гбит/сек урсгал дамжуулах угсралт суурилуулалт, хэмжилт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэн, үйлчилгээ үзүүлж эхлээд байна.

СҮЛЖЭЭНИЙ БЭЛЭН БАЙДЛЫН ТҮВШИН

Компанийн чанарын бэлэн байдлын түвшин /KPI/ Улс хоорондын сүлжээ - 99.98%, Үндсэн сүлжээ - 99.96%, Өгөгдлийн сүлжээ - 99.98%, Кабель шугамын чанар - 99.62% гүйцэтгэлтэй гарлаа.


Зураг 2. Үндсэн сүлжээнд гарсан гэмтлийн хугацаа



Зураг 3. Зай тэжээлийн гэмтэл




Зураг 4. Тоног төхөөрөмжийн гэмтэл



Үндсэн сүлжээнд нийт 336 сум суурин газар холбогдож E1, STM, IP холболтоор орон нутгуудад харилцагч компаниудын үйлчилгээг хүргэж байна.

Кабель шугамын байгууламжинд:

Улаанбаатар хотын хэмжээнд 6 дүүрэг 7 станцын хүрээнд 8'952ш худаг, 629'465 метр сувагчлалын угсралт, ашиглалт үйлчилгээг хариуцан ажиллаж байна.



Зураг 5. Улаанбаатар хотын цагирган сүлжээ бүхий сувагчлалын трасс

2020-2021 онуудад Баянхошуу дэд төв, Сэлбэ дэд төвийн хүрээнд нийт 5688 м сувагчлал шинээр хийгдсэн.

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд "Худаг сувагчлал кабель шугам"-ын төлөвлөлтийг боловсруулж, санал оруулсан.

1.4 БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ

Компани нь 1622 үндсэн болон гэрээт ажилтантайгаар улсын хэмжээний үндсэн сүлжээ, дамжуулах байгууламж, кабель шугамын сүлжээний ашиглалт үйлчилгээг хариуцаж, төрийн өмчийн менежментийг зохион байгуулах, сүлжээ бүхий оператор компаниудын техникийн ашиглалт үйлчилгээг гэрээгээр хариуцах зэрэг ажлыг хийж гүйцэтгэж байна.

Хууль, эрх зүй, архив албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд:

- Компанийн 95 эрх бүхий албан тушаалтны ХАСХОМ
- Компанийн эрх бүхий албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 15 этгээдийн ХАСУМ хүргүүлсэн

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс нийт 1056 ш албан бичиг, хүсэлт хүлээн авч, 921 ш хариу албан бичиг боловсруулж илгээсэн байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, холбогдох заавар, журмын дагуу компанийн газар нэгжүүдээс 2020 онд хөтөлсөн 467 хадгаламжийн нэгж материалыг архивласан.

Зураг 6.



Дүрэм журам

Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулах хүрээнд нийт 368 ажилтан хамруулан хийсэн судалгаан дээр үндэслэн компанийн Хөдөлмөрийн дотоод журамд ажлын цагийг 08:30-16:30 болгон өөрчлөлт оруулсан.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан “Компанийн дотоод журам”-ийг шинэчлэн, хөдөлмөрийн харилцаандаа мөрдөж байна.

Зураг 7. Хүний нөөцийн үзүүлэлтүүд



Сургалтын үйл ажиллагаа

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас байгууллагын хүний нөөцийн бодлого дахь сургалтын үйл ажиллагаа алдагдаж эхэлсэнтэй холбогдуулан ажилтнуудаа онлайнаар суралцах, мэдээ мэдээллээр хангах үүднээс “Jarvis LMS- цахим сургалтын систем”-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Уг системд

- 717 ажилтанд хэрэглэгчийн эрх үүсгэж,
- 547 видео хичээл
- 138 PDF хичээл
- Аттестатчиллын шалгалтын 2800 асуултын сан үүсгэсэн.


“Jarvis LMS- цахим сургалтын систем”-д нэвтрэх, хэрхэн ажиллах зааварчилгааг сургалт хэлбэрээр зохион байгуулсан.

Хүснэгт 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалт	Тоо	Хамрагдсан хүн
Төлөвлөгөөт	14	1806
Төлбөрт	2	
Түгээмэл мэргэжлийн	4	
НИЙТ	20	

Аттестатчиллын шалгалтыг Улаанбаатар хотын хэмжээнд хууль эрх зүй, хүний нөөц, дамжуулах байгууламж, мэдээллийн технологи, кабель шугам, зай тэжээл цахилгаан хангамж, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал эрүүл ахуй, хөрөнгө оруулалт зэрэг тухайн ажлын байранд тохирсон 23 чиглэлээр 3 үе шаттайгаар, Jarvis-lms програмаар болон уламжлалт хэлбэрээр зохион байгууллаа. Орон нутгийн нийт ажилтнуудыг 2022 онд хамруулахаар зохион байгуулалтын бэлтгэл ажлаа хангаад байна.

Зураг 8. Сургалтын үйл ажиллагаа



Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр:

Улаанбаатар хотын харьяа 6 объектод гамшгийн эрсдлийн үнэлгээ хийлгэсэн. Үүний дагуу Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж зөвлөмжийн дагуу хийгдэх ажлын төлөвлөгөөг гаргаж ажиллаж байна.

ХАБЭА-н урьдчилсан зааварчлага, ээлжит, ээлжит бус зааварчлагыг давхардсан тоогоор 3010 ажилтнуудад тухай бүр өгч ажилласан. Мөн цаг үеийн байдалтай холбогдуулсан сэрэмжлүүлэг мэдээллүүдийг компанийн нийт ажилтнуудад мэйл болон сошиал сувгаар дамжуулан хүргүүлсэн.



ERP - БАЙГУУЛЛАГЫН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ

Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах ERP системийн гүйцэтгэл 80% ажиллаж байгаа бөгөөд төв аппаратын хэмжээнд нийт 1977 баримт бичгийн эргэлт хийгдэж 1037 баримт бичиг ERP системээр дамжсан байна.

1.5 2021 ОНД ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТ БА ГҮЙЦЭТГЭЛ

Нэг. Стратеги төлөвлөгөөний техник технологийн 3 дугаар зорилтын хүрээнд сумдын түвшний сүлжээний багтаамжийг өргөтгөж, үндсэн сүлжээний урсгал түгээх үйл ажиллагааг бүрэн шинэчилнэ.

- Сумдын түвшний дамжуулах сүлжээний багтаамжийг нэмэгдүүлэх зорилгоор БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 270 сумдын хамруулан төслийн ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.
- Компани өөрийн хөрөнгө оруулалтаар өгөгдлийн сүлжээний өргөтгөлийн хүрээнд 48 сумын дамжуулах багтаамжийг 1Гбит/сек болгон өргөтгөлөө.

Хоёр. Монгол Улсын шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй сумдыг холбох ажлыг өөрийн хөрөнгөөр болон бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар- Хилийн боомтуудыг шилэн кабелийн сүлжээнд холбох ажлын хүрээнд Дорнод аймаг Матад сум-Газрын тосны 19-р талбай- Газрын тосны 21-р талбай-Баянхошуу боомт чиглэлийн газрын нийт 304.9 км дэд бүтцийг байнгын ашиглалтад хүлээн авлаа.
- БНҮҮС-ын хөрөнгөөр Булган аймгийн Хангал сумын Хялгант, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Гурванбаян, Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан багуудын шилэн кабелийн сүлжээг байгуулах ажлыг хянаж хүлээн авлаа.
- Компани өөрийн хөрөнгө оруулалтаар - Дорнод аймгийн Халхгол сумыг шилэн кабелийн сүлжээнд холбох ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлсэн.

Гурав. Технологийн байр, цамхаг болон нөөц тэжээлийг шинэчлэх, сайжруулах чиглэлээр төсөл хэрэгжүүлж ашиглалтын нөхцөлийг стандартын шаардлагад нийцүүлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

- “Сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх Хур систем” төслийн хүрээнд 2021 онд 25 сумын байр (улсын комисс хүлээн авсан-16 байр) шинээр баригдаж, сумдын 179 байранд шинэчлэл, засвар хийгдэж, 243 байршилд нэгдсэн нөөц тэжээлийн үүсгүүр суурилуулагдаж, 61 суманд цамхагуудыг байнгын ашиглалтанд хүлээн авсан.
- Компани өөрийн хөрөнгө оруулалтаар - Булган аймгийн Бугат сум, Төв аймгийн Жаргалант сумын техникийн байрыг шинээр барьж ашиглалтын чанар, нөхцөлийг сайжруулж, хэвийн үйл ажиллагааг хангасан. Баянхонгор аймгийн төвийн барилгын дотор талын хэсэгчилсэн их засвар хийсэн.

Дөрөв. Үүлэн тооцооллын дэд төвийг шинээр байгуулж, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлнэ.

- Компанийн үүлэн тооцооллын дэд төвийг байгуулах ажлын хүрээнд Дата хадгалах /storage server/, серверүүдээ удирдах зориулалттай контроллер /controller/ серверүүдийн үндсэн тохиргоонуудыг хийж, Openstack-д суурилсан Fibo cloud системийг суурилуулах ажлыг эхлүүллээ. Цар тахлын нөхцөл байдлын улмаас зардлын хэмнэлт явуулж, лиценз програм хангамжийн ажлыг түр хугацаанд хойшлууллаа.

1.6 ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 226, 238 дугаар тогтоол, 2021 оны 1, 2, 27, 78, 91, 104, 115, 154, 176 тогтоолуудыг тус тус үндэслэн гамшгаас хамгаалах Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг, Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Засгийн газар, Улсын Онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрт нийцүүлэн:

- Төв болон орон нутгийн салбарын ажилтнуудын ажлын цагийг хорогдуулах, үндсэн цалин, урамшууллыг нь бүтэн олгох
- Гэрээсээ цахимаар ажиллах нөхцөл боломжоор ханган ээлжийн хуваарьт оруулан ажиллуулах
- Ээлжийн инженер техникийн болон үйлчилгээний ажилтнуудыг сүлжээний бэлэн байдал, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллуулах зэргээр хөдөлмөрийн хуваарь, ажлын цагийг зохион байгуулсан.

Гамшгаас хамгаалах Бүх нийтийн байдлын зэрэг, Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд мэдээлэл харилцаа холбооны хэвийн нөхцөл, техникийн бэлэн байдлыг бүрэн хангаж, шуурхай ажиллах зорилгоор компанийн хэмжээнд Ерөнхий эргүүл, хариуцлагатай жижүүрийг томилж Харилцаа, холбоо мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран ажилласан байна.

Цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нийт 10 объектод 800 удаа ариутгал хийсэн. Улсын онцгой комиссын шийдвэрээр ОБЕГ-ын харьяанд цар тахлын нөлөөллийг бууруулах, тэмцэх ажилд компанийн 7 тээврийн хэрэгслийг дайчлан ажиллууллаа.

Гамшгаас хамгаалах штаб байгуулж, ажилчдын эрүүл мэндийг халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх, цаг алдалгүй арга хэмжээ авах төлөвлөгөөний дагуу ажиллах Нэгдсэн мэдээллийн сан FACE 2.0 програмаар асуумж явуулж ажилтнуудын эрүүл мэндийг хянаж ажиллалаа.

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед компанийн тасралтгүй ажиллагааг хангахын тулд Санхүүгийн Unicus програм, Байгууллагын нөөцийн удирдлагын систем ERP, Нэгдсэн мэдээллийн сан FACE 2.0 програм дээр гэрээсээ ажиллах техникийн боломжийг бүрдүүлсэн. Компанийн нийт ажилтнуудыг ковидын вакцинд хамрагдах ажлыг зохион байгуулж нийт ажилтны 56%-г 1, 2, 3-р тунд хамруулан ажилласан.

